

# “ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ ЖУРАМ”- ЫН ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ТӨСӨЛ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар төмөр замын тээврийн байгууллага, төмөр замын тээвэрт оролцогчдын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд гарсан осол, зөрчлийг ангилах, шинжлэн шалгах, шалтгааныг нь тогтоох, бүртгэх, мэдээлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Үйлдвэрлэлийн ослыг шинжлэн шалгахтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулахгүй.

1.3. Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, төмөр замын тээврийн байгууллага, оролцогч нь осол, зөрчлийг эрүү, зөрчил, хөдөлмөрийн харилцаатай холбогдуулан шалгаж байгаа эсэхээс үл хамааран шинжлэн шалгах, шалтгааныг нь тогтоох, мэргэжлийн дүгнэлт гаргах, бүртгэх, үр дагаврыг арилгах, дахин гаргахгүй байх ажлыг хэрэгжүүлнэ.

1.4. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь энэхүү журамд нийцүүлэн осол, зөрчлийг судлан шалгаж дүгнэлт гаргах, шалтгаан, үр дагаврыг арилгах журам эсвэл заавар батлан хэрэгжүүлнэ.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ ОСОЛ, ЗӨРЧИЛ

2.1. Осолд дараах нөхцөл байдал үүссэнийг тооцно:

2.1.1. Зорчигчийн болон ачааны галт тэрэг, сэлгээний бүрэлдэхүүн нь өөр галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүнтэй мөргөлдсөний улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хүний амь нас хохирсон, бусдын эд хөрөнгөд их хэмжээний хохирол учруулсан, хөдлөх бүрэлдэхүүн эвдэрч дахин ашиглах боломжгүй болсон, их засварт орох хэмжээний гэмтэл үүссэн;

2.1.2. Хөдлөх бүрэлдэхүүн замаас гарсны улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хүний амь нас хохирсон, бусдын эд хөрөнгөд их хэмжээний хохирол учруулсан, хөдлөх бүрэлдэхүүн эвдэрч дахин ашиглах боломжгүй болсон, их засварт орох хэмжээний гэмтэл үүссэн;

2.1.3. Аюултай ачаа тээвэрлэх, ачих, буулгах явцад аюултай ачаа асгарсан, шатсан, дэлбэрсэн, урвалд орсны улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хүний амь нас хохирсон, байгаль орчин болон бусдын эд хөрөнгөд их хэмжээний хохирол учруулсан.

2.2. Энэхүү журмын 2.1 дэх заалтад заасан үр дагавар үүсээгүй, бусдад хохирол учруулсан дараах нөхцөлийг зөрчилд тооцно:

2.2.1. хөдлөх бүрэлдэхүүн мөргөлдсөн-Хоорондын зам, өртөө, зөрлөгт галт тэрэг өөр галт тэрэгтэй, хөдлөх бүрэлдэхүүнтэй мөргөлдсөн, сэлгээ, зэхэлт, бусад хөдөлгөөний үед хөдлөх бүрэлдэхүүн өөр хоорондоо мөргөлдсөн, мөн хязгаарын шонгийн гадна нэг хөдлөх бүрэлдэхүүн нөгөөгийн хажуугаас мөргөснөөс болж хөдлөх бүрэлдэхүүн гэмтсэн;

2.2.2. хөдлөх бүрэлдэхүүн замаас гарсан-Өртөө, зөрлөг, хоорондын зам, салбар замд галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн, зэхэлт хийх үед хөдлөх бүрэлдэхүүний хос дугуй зам төмрийн толгойноос унасан;

2.2.3. тээврийн хэрэгсэл дайрагдсан-Гарам эзэмшигч нь төмөр замын гарам ашиглах журмын шаардлага, үйл ажиллагаа зөрчсөнөөс хөдлөх бүрэлдэхүүнд тээврийн хэрэгсэл дайруулсан;

2.2.4. вагон, чингэлэг дэх ачаа шатах-Хоорондын зам, өртөө, зөрлөг, салбар замд вагон, чингэлэгт ачсан ачаа шатсан тохиолдол;

2.2.5. сум зүссэн-Өртөө, зөрлөг, салбар замд сум зүссэн;

2.3. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчид нь энэхүү журмын 2.1, 2.2 дахь хэсэгт зааснаас бусад гологдол, дутагдал гарсан тохиолдолд байгууллагын дотоод журмаар тусгайлан бүртгэж, тэдгээрийг шинжлэн шалгаж, дахин давтагдахгүй байх арга хэмжээг авч ажиллана.

### ГУРАВДУГААР БҮЛЭГ ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ МЭДЭЭЛЭХ

3.1. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь нөхцөл байдал бий болсныг мэдсэн даруйд энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заасны дагуу төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шуурхай мэдээлнэ:

3.1.1. энэ журмын 2.1, 2.2-д заасан нөхцөл байдал бий болсон;

3.1.2. галт тэргэнд хүн, мал дайрагдсан.

3.2. Энэхүү журмын 2.1, 2.2-т заасан нөхцөл байдал бий болсон буюу хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хүний амь нас хохирсон, байгаль орчин болон бусдын эд хөрөнгөд их хэмжээний хохирол учруулсан, хөдлөх бүрэлдэхүүн их хэмжээгээр гэмтсэн тохиолдолд Төмөр замын цагдаагийн газар болон орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн жижүүрт шуурхай мэдээлнэ.

3.3. Шуурхай мэдээлэл нь ямар үйл явдал болсон, тухайн осол, зөрчил болсон газар, огноо, цаг, үүссэн хохирлын шинж чанар, хэр хэмжээ, холбогдох тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн нэр, холбогдох утас, цахим хаяг зэргийг багтаасан байна.

3.4. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь энэ журмын 3.1-д заасан мэдээллийг баталгаажуулж тухайн нөхцөл байдал бий болсноос хойш ажлын 12 цагийн дотор энэхүү журмын хоёрдугаар хавсралтад заасан загварын дагуу бичмэл мэдээллийг төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагад тус хүргүүлнэ.

3.5. Осол, зөрчил гарсан тохиолдолд тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч дараах үүрэг хүлээнэ:

3.5.1. хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалж анхан шатны тусламж үзүүлэх;

3.5.2. хамгийн ойр орших эмнэлэг, онцгой байдлын байгууллага, суурь бүтэц эзэмшигч болон Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэх;

3.5.3. осол, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтооход ашиглагдаж болох баримт бичиг, замын байгууламж болон хөдлөх бүрэлдэхүүний эд анги, бүрдэл хэсэг, эд зүйлийг хэвээр нь хадгалж, хамгаалах, баримтжуулах;

3.5.4. хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд зайлшгүй шаардлагатай бол осол, зөрчлийн улмаас эвдэрч гэмтсэн хөдлөх бүрэлдэхүүн, барилга, байгууламж, эд зүйлсийг эвдэх, задлах, нээх, замаас зайлуулах, аюултай ачааны хор хөнөөлийг саармагжуулах зэрэг шуурхай арга хэмжээ авах;

3.5.5. хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бусад шуурхай арга хэмжээ авах.

3.6. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь гарсан осол, зөрчлийн шалтгаан, үр дагаврыг арилгах, энэ журмын 3.5-д заасныг зөрчихгүйгээр хөдөлгөөнийг сэргээх арга хэмжээг авч эхлүүлнэ.

3.7. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчоос бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллага осол, зөрчил болсон тухай холбогдох байгууллагуудад мэдээлэл ирүүлбэл тэдгээр мэдээллийн үнэн, бодитой эсэхийг төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нар нягтлан шалгасны үндсэн дээр шинжлэн шалгана.

#### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ

4.1. Шинжлэн шалгах ажиллагаа нь хараат бус, бие даасан байж, осол, зөрчил гарсан шалтгаан, нөхцөлийг үнэн, зөв тогтоох, цаашид давтан гарахаас урьдчилан сэргийлнэ.

4.2. Осол, зөрчлийг шинжлэн шалгах, шалтгааныг нь тогтоох, бүртгэх үйл ажиллагаа нь мэдээлэл цуглуулах, холбогдох баримт бичиг бүрдүүлэх, судлан шинжлэх, дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, мэдээлэх, архивлах гэсэн ерөнхий дарааллаар явагдана.

4.3. Энэ журмын 2.1-т заасан нөхцөл байдал бий болсон бол төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон ажлын хэсэг шинжлэн шалгаж, шалтгааныг нь тогтооно.

4.4. Энэ журмын 2.2-т заасан нөхцөл байдалд тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч хэд хэдэн этгээд холбогдсон бол төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон ажлын хэсэг шинжлэн шалгаж, шалтгааныг нь тогтоож болно.

4.5. Энэ журмын 2.2-т заасан нөхцөл байдал бий болсон бол төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагч шинжлэн судалж шалтгааныг нь тогтооно.

4.6. Энэхүү журмын 4.3, 4.4 дэх хэсэгт заасан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд төмөр замын тээврийн хяналт хариуцсан шинжээч, улсын ахлах байцаагч, харьяалах суурь бүтэц эзэмшигч, холбогдох төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагын төлөөллийг хамруулсан байна.

4.7. Энэхүү журмын 2.1, 2.2 дахь хэсэгт заасан нөхцөл мөн гологдол, дутагдал үүссэн үед төмөр замын байгууллага, оролцогч нар ажлын хэсэг байгуулж эсвэл асуудлын судалж шалтгааныг тогтоох хурал зохион байгуулж, үр дагаврыг арилгаж, дахин гарахгүй байх урьдчилан сэргийлэх ажлыг цаг алдалгүй яаралтай хийнэ.

4.8. Төмөр замын тээвэрт оролцогч нь гологдол, дутагдлыг мэдээлэл, холбогдох баримт бичгийг сар бүр эцэст төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

4.9. Шаардлагатай бол төмөр замын тээврийн хяналтын улсын ахлах байцаагчийн шийдвэрээр гологдол, дутагдлыг төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагч шинжлэн судалж, дүгнэлт гаргаж болно. Дүгнэлтэд гологдол, дутагдлын шалтгаан үндэслэлтэй эсэх, үр дагавар байгаа эсэх, цаашид авах арга хэмжээний санал тусгасан байна.

4.10. Осол, зөрчил гарсан үед тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь осол, зөрчил шинжлэн шалгах ажлын хэсэг томилогдон ажиллаж эхлэх хүртэл, эсхүл ажлын хэсгийн ахлагчийн даалгаснаар осол, зөрчлийн шинж чанараас хамааран дараах ажил үүргийг гүйцэтгэнэ:

4.10.1. хурд хэмжигчийн тууз, галт тэрэгний хөдөлгөөний мэдээллийг бүртгэх төхөөрөмж /мэдээлэл хадгалагч/, галт тэрэгний биечилсэн хуудас, тоормосны хангамжийн мэдээлэл, хурд хязгаарласан тухай анхаарамж, зүтгүүрийн ширээний журнал, бусад баримт бичгийг шалгаж, шаардлагатай бол эхээр нь буюу хуулбарлан авах;

4.10.2. осол, зөрчил гарсан газар, суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд үзлэг хийсэн тухай акт үйлдэх;

4.10.3. суурь бүтэц, замын байгууламж болон хөдлөх бүрэлдэхүүний гэмтлийг тодорхойлох;

4.10.4. осол, зөрчлийн нөхцөл байдал, суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний байдал, эвдрэл гэмтэл, гадны болон ойр орчимд байгаа эд зүйлс зэргийг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулах;

4.10.5. осол, зөрчилд холбоотой ажилтан, гэрчийн этгээдээс бичгээр тодорхойлолт авч, шаардлагатай бол дуу болон дүрсний бичлэгээр баталгаажуулах;

4.10.6. осол, зөрчил болсныг баталгаажуулах зорилгоор авсан гэрэл зураг, дуу, дүрс бичлэг, ослын дараах суурь бүтцийн тоног төхөөрөмж, хөдлөх бүрэлдэхүүний гэмтэл, арчлалтын норм хэмжээний өөрчлөлт, хөдлөх бүрэлдэхүүний байршил ба замаас гарсан эхлэл төгсгөлийн ул мөр зэргийг заасан бүдүүвч зураг гаргах;

4.10.7. осол, зөрчил гарах үед цаг агаарын байдал ямар байсан тухай тэмдэглэл хийж, шаардлагатай бол холбогдох баримтыг авна.

4.11. Ажлын хэсэг шинжлэн шалгах, шалтгааныг нь тогтоох ажиллагааг хийж, дүгнэлтийг ажлын 14 хоногт багтаан гаргана. Нэмэлт баримт, мэдээлэл, шалган турших ажиллагаа шаардлагатай бол шинжлэн шалгах ажиллагааг сунгаж болно.

4.12. Дүгнэлтийн шийдвэрийг ажлын хэсгийн гишүүдийн дийлэнх олонх буюу 2/3 -аас дээш саналаар гаргана. Дүгнэлтэд ажлын хэсгийн бүх гишүүд гарын үсэг зурах ба дүгнэлттэй санал нийлэхгүй гишүүн тэр тухайгаа тэмдэглэн гарын үсэг зурж хавсаргана.

4.13. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн томилсон ажлын хэсгийн дүгнэлт зохих ёсоор хийгдэж, шаардлага хангасан эсэхийг улсын байцаагч, улсын байцаагчийн ахалсан ажлын хэсгийн дүгнэлтийг улсын ахлах байцаагч тус хянаж, шаардлагатай гэж үзвэл дүгнэлтийг хүчингүй болгож, дахин шинжлэн шалгуулах арга хэмжээ авна.

4.14. Дахин хийх шинжлэн шалгах ажлын хэсэгт өмнө ажлын хэсэгт оролцсон улсын байцаагч, албан тушаалтныг оролцуулахгүй.

4.15. Осол, зөрчлийн шалтгааныг нь тогтоохдоо нотлох баримт, суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн тэдгээрийн эд анги, техник, тоног төхөөрөмжийг эвдэж гэмтээхгүй, үрэгдүүлэхгүй, сөрөг нөлөөлөл үзүүлэхгүйгээр ажиллах, шаардлагатай бол томоохон эд анги болон аюултай ачааг зөөвөрлөн саадгүйгээр шилжүүлэхдээ шинжээчдийн хяналт дор, мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор гүйцэтгүүлнэ.

4.16. осол, зөрчлийг шинжлэн шалгах, шалтгааныг нь тогтоох явцад дараах мэдээллүүдийг өөр зорилгоор бусдад ашиглуулахгүй, мөн задруулахгүй. Үүнд:

4.16.1. аливаа этгээдээс авсан тайлбар, тодорхойлолт;

4.16.2. энэхүү журмын 4.7.1-4.7.6-д заасан ажил үүрэг, /акт, тодорхойлолт, зураг, дуу, дүрс бичлэг, ослын дараах суурь бүтцийн тоног төхөөрөмж, хөдлөх бүрэлдэхүүний гэмтэл, арчлалтын норм хэмжээний өөрчлөлт, хөдлөх бүрэлдэхүүний байршил ба замаас гарсан эхлэл төгсгөлийн ул мөр зэргийг заасан бүдүүвч зураг/;

4.16.3. осол, зөрчилд өртсөн хүмүүсийн эрүүл мэнд, хувь хүний болон хувийн амьдралын талаарх мэдээлэл;

4.16.4. гарсан осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд оролцогчдын илэрхийлсэн санал, дүгнэлт, тэдгээртэй холбоотой мэдээлэл;

4.16.5. гарсан осол, зөрчлийг шинжлэн шалгагч нарын хүрээнд болсон бодит хяналтын төхөөрөмжийн бичлэгийн талаарх аливаа үнэлэлт, тодорхойлолт, дүгнэлт.

4.17. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд гарсан осол, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээг төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага төлөвлөн хэрэгжүүлнэ.

4.18. Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагууд гарсан осол, зөрчлийг дахин давтахгүй байх ажлыг зохион байгуулна.

4.19. Энэхүү журмын 2.1, 2.2 дахь заалтад заасан нөхцөл байдал үүссэн үед хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд үзлэг хийх болон дахин ашиглах боломжгүй, их засварт оруулах хэмжээний эвдрэлтэй эсэх дүгнэлт гаргахад төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагчийг заавал оролцуулна эсвэл зөвшилцөнө.

## ТАВДУГААР БҮЛЭГ ОСОЛ, ЗӨРЧЛИЙН ДҮГНЭЛТЭД ХАВСАРГАХ БАРИМТ, МЭДЭЭЛЭЛ

5.1. Ажлын хэсгийн дүгнэлтэд энэ журмын 4.6-д заасан ажиллагааг хийж цуглуулсан мэдээллээс гадна дараах баримт, мэдээллийг хавсаргасан байна:

5.1.1. гэмтсэн, хохирсон, хүмүүсийн нэрсийн жагсаалт, гэмтлийн байдлын талаарх эмнэлгийн урьдчилсан дүгнэлт;

5.1.2. хохирлын хэмжээг тодорхойлсон баримт;

5.1.3. шаардлагатай тохиолдолд хийгдсэн шалган турших ажиллагааны акт, дүгнэлт;

5.1.4. галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмагийн хуулбар;

5.1.5. суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын үеийн техникийн баримт бичиг, бүртгэл, тайлангийн хуулбар /осол, зөрчлийн шалтгааныг тогтооход шаардлагатай бол/;

5.1.6. осол, зөрчил болсныг баталгаажуулах зорилгоор авсан гэрэл зураг, дуу, дүрс бичлэг, ослын дараах суурь бүтцийн тоног төхөөрөмж, хөдлөх бүрэлдэхүүний гэмтэл, арчлалтын норм хэмжээний өөрчлөлт зэргийг заасан бүдүүвч зураг;

5.1.7. тухайн үеийн цаг уурын байдлын талаарх лавлагаа;

5.1.8. техникийн мэдлэгийн шалгалтын баримт, ажлын байрны тодорхойлолт, дадлага туршлагын байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаанд хамрагдсан эсэх, эмнэлгийн үзлэгт орсон тухай магадалгаа, ажил, амралтын дэглэмийн тухай мэдээлэл;

5.1.9. шаардлагатай бусад баримт.

#### ЗУРГАДУГААР БҮЛЭГ ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ БҮРТГЭХ, МЭДЭЭ ГАРГАХ

6.1. Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь осол, зөрчлийг бүртгэж, баримтыг хадгална.

6.2. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь осол, зөрчил, гологдол, дутагдлыг бүртгэж, баримтыг хадгална.

6.3. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь энэ журамд заасан осол, зөрчлийн мэдээг Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журамд заасан хугацаанд, тогтоосон маягтын дагуу Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

6.4. Осол, зөрчлийн жилийн мэдээ, баримтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хадгална.

#### ДОЛДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

7.1. Энэхүү журмын хэрэгжилтэд төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нар тус тусын бүрэн эрхийн хэмжээнд хяналт тавина.

7.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Төмөр замын тээврийн тухай, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.